



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/508

Мөрөн сум

Усан замын тээвэрлэлтийн талаар
авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Усан замын тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 7.1.8, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.9, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Зам, тээврийн хөгжлийн яамны Монгол Улсын Далайн захиргааны 2024 оны 01/372 дугаар албан бичиг, байгаль, цаг уурын нөхцөл байдлын мэдээллийг үндэслэн усан замын тээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэх энэ жилийн хөвөлтийн улирлын дуусах хугацааг 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр байхаар тогтоосугай.

2. Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгчдийн тээвэрлэлтийн үйл ажиллагааг зогсоож, хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Далайн захиргаа (Б.Сайнбаяр), Онцгой байдлын газар (Дэд хурандаа С.Ганболд), аймгийн Цагдаагийн газар (Дэд хурандаа Д.Мөнхжаргал), Байгаль орчин, аялал, жуулчлалын газар (П.Мөнхжаргал), Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа (Г.Энхбаяр)-нд тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийг эс зөвшөөрвөл оролцогчдод мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ